

<https://doi.org/10.69561/mjac.v25i48.3630>

Article | Fasc.14

Баядын ихэлч Жутаан Хумбаагийн ихэл татах арга барилын онцлог

Нансалжавын Магсаржав

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
ORCID: <https://orcid.org/0009-0006-0940-4302>
Холбоо барих зохиогч: n.magsarjav0520@gmail.com

Хураангуй: Ихэл нь түүхэн цаг хугацаанд хөгжин дэлгэрч ирэхдээ хөгжимдөх арга барилаа хадгалсаар ирсэн хэдий ч өнөө үед ихэлийн татлагын язгуур байдал нь алдагдаж, бүс нутаг бүрийн угсаатны бүлгийн өвөрмөц шинжүүд өөр хоорондоо холилдоход хүрч, устаж цөөрсөөр байна. Иймээс ихэлийн татлагыг гарамгай эзэмшсэн соёлын биет бус өвийн 2020 оны шилдэг өвлөн уламжлагч Увс аймгийн Малчин сумын ихэлч, бийч Жутаан Хумбаагийн ихэл татах арга барилын талаар авч үзэх болно.

Түлхүүр үгс: *ихэл, ихэлийн татлага, ноот*

A special feature of the technique of the ikhel, performed by Jutaan Khumbaa, ikhel-player of the bait

Magsarjav Nansaljav

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University of
Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
ORCID: <https://orcid.org/0009-0006-0940-4302>
Corresponding author: n.magsarjav0520@gmail.com

Abstract: When the ikhel has developed and spread out for a long historic period it has preserved its performing technique. But at present the tradition of this performing technique of the ikhel has been lost and the peculiarities of the ethnic group of each region have to be mixed with each other and have been destroyed and decreased. So we considered the technique of the ikhel, performed by Jutaan Khumbaa, ikhel-player and bii dancer of Malchin soum, Uvs province, who is the best tradition bearer of the year of 2020 of the intangible cultural heritage.

Keywords: *ikhel, performing technique of the ikhel, note.*



Оршил

Монголын олон угсаатны бүлгийн дунд хуурдахад зориулсан татлага аязууд бий. Татлагуудаас үзэхэд хөгжимдөх арга, донж маяг (манера¹) хэмээх ойлголтын хүрээнд авч үзэж болох мэт. Ихэлийн татлага татдаг өвлөн уламжлагчдыг тодруулахын тулд цаашид угсаатны бүлэг бүрээр судалгааг хийж, эрт үеэс уламжлагдан ард түмний дотор тархсан тэдгээр татлагуудыг ноотолж, сургалт, судалгааны эргэлтэд оруулах, уламжлалт арга барилаар нь авч үлдэх хэрэгцээ шаардлага үүссэн тул энэхүү сэдвийг сонгон судлах үндэслэлээ болгов.

Судалгааны арга зүй

Тус судалгаанд ярилцлага, тайлан тайлбарлах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, баримтжуулалтын аргуудыг ашиглав.

Судалгааны үр дүн

Тус судалгааг хийхдээ Увс аймагт очин, өвлөн уламжлагч Ж.Хумбаатай уулзаж, түүний ихэл татах арга барил, баяд татлагын талаар ярилцаж, баримтжуулсан ба ихэлч Ж.Хумбаагийн ихэл татах арга барилын онцлогийг тодруулахын тулд ихэлийн татлагыг 3 төрлөөр, ихэлийн татлагад илрэх шинжийг 3 төрөл 13 зүйлээр, ихэл татах аргыг 4 төрөл 23 зүйлээр ангилан үзэж үр дүнг гаргав.

Ойрадын Баяд, Дөрвөд, Захчин, Урианхай, Хотон угсаатны бүлгийн ихэлийн татлагын талаар бичиж, ноотын хамт судалгааны эргэлтэд оруулсан эрдэмтэн, судлаачдын талаар авч үзье.

Судлаач, доктор (Sc.D), профессор Л.Эрдэнэчимэг “Хөгжимчид өөрийн сэтгэлгээний онцлогийг хөгжмөөр илэрхийлж байгаа нэгэн жишээ татлага юм. Бийгийн татлага татахад ихэнхдээ огцом таталт, түлхэлт шаардагддаг” (Эрдэнэчимэг 1994, 5) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Судлаач, доктор (Ph.D) Д.Энхцэцэг “Татлага бол хуурын уран сайхны үндэсний хэв маягийг илэрхийлэгч үндсэн “бүтээмж”, хуур бол татлагыг хөгжмийн урлагийн нэн өвөрмөц төрөл болохыг илэрхийлэгч үндсэн “зэмсэг” юм” (Энхцэцэг 2018, 43) гэж тодорхойлжээ.

Харин судлаач, доктор (Ph.D) Э.Зулцэцэг “Татлага бий биелгээтэй нарийн дэгээр холбогдохоос гадна, тусдаа дан хөгжмөөр илэрхийлэх боломжтой байдаг нь сэтгэлгээтэй холбоотой. Давтамж нь татлагын зохиомжийн гол илэрхийллийн нэг бөгөөд аягийг олон дахихдаа бийчийн давтамжит хөдөлгөөнтэй хослуулан гаргадаг онцлогтой юм” (Зулцэцэг 2019, 69) гэжээ.

Ихэлийн татлагад хөг чухал бөгөөд дөрөвц, тавц гэсэн хоёр хөгтэй байна. Бийгийн татлагыг ихэнхдээ дөрөвц хөгөөр татдаг. Монголчууд морин хуур гэхээр уртын дуутай холбодогтой адилаар бий нь ихэлтэй салшгүй холбоотой. Учир нь Баядын язгуур соёлын нэг онцлог нь ихэл, бий юм. Баядууд бийлэхдээ хаан суудлаар сууж, хормойгоо хөдөлгөхгүйгээр толгой нь гараа дагаж бийлдэг онцлогтой.

Баядууд бийгийн арвин баялаг өв сантай ард түмэн. Үүнд: “Цацал”, “Мөргүүл”, “Элхэндэг”, “Дөрвөн ойрад”, “Жороо морь”, “Жалам хар”, “Елхэндэг”, “Балчин хээр” зэрэг төрлүүдтэй (Соёл урлагийн их сургууль 2018, 23).

¹ Манера гэдэг нь франц гаралтай үг бөгөөд монголоор “донж маяг” гэсэн үг.

Ихэлийн татлагыг доорх 3 төрлөөр авч үзэн тухайн угсаатны бүлгийн ихэлийн татлагад илрэх шинж болон ихэл татах арга барилыг тодруулахын тулд төрөл тус бүрд жишээ болгон нэг татлагыг сонгон авч байна. Үүнд:

1. Бийгийн татлага болох “Элхэндэг”, “Жороо морь”
2. Дуут бийгийн татлага болох “Ихэлээрээ наадъя”
3. Ихэлийн татлага болох “Дөрвөн Ойрад”

Эдгээр татлагуудад анализ хийхдээ:

- Ихэлийн татлагад илрэх шинжээр нь хурдын хувьд *тэнүүн, удаан, тайван, аядуу, тогтуун, хөгжүүн, түргэн*, хөгийн хувьд *дөрөвц, тавц*, хэмжээний хувьд *2/4, 4/4, 6/8, 3/4*
- Ихэл татах арга барилаар нь ихэл татах аргынх нь хувьд *татах, түлхэх, гүйлгэх, сийгүүлэх, исгэрүүлэх, товшиж татах*, нумын техникийн хувьд *шулуун, огцом, сугсраа, үсэргээ, холбоо*, цохилгын хэлбэрийн хувьд *том, жижиг, жиргүүлэх, дан, давхар, далд, угтаа, солбио, залгаа*, дарлагын төрлийн хувьд *битүү, гулсаа, чичиргээ* гэх мэт ангилан *Хүснэгт 1*-д үзүүлэв.

Хүснэгт 1. Элхэндэг, Жороо морь, Ихэлээрээ наадъя, Дөрвөн Ойрад татлагад хийсэн анализ

"Элхэндэг", "Жороо морь", "Цагал", "Мөргөл" татлагад хийсэн ажиглалт		ИХЭЛЧ ЖУТААН ХУМБАА				
		ЭЛХЭНДЭГ	ЖОРОО МОРЬ	ИХЭЛЭЭРЭЭ НААДЬЯ	ДӨРВӨН ОЙРАД	
ИХЭЛИЙН ТАТЛАГА АДИЛГРЭХ ШИНЖ	Хурд [Темп]	Тэнүүн [Largo]	+			
		Удаан [Adagio]				+
		Тайван [Andante]				
		Аядуу [Moderato]			+	
		Тогтуун [Sostenuto]				
		Хөгжүүн [Allegretto]				
		Түргэн [Allegro]		+		+
	Хөг [Строй]	Дөрөвц [Кварт]	+	+	+	
		Тавц [Квинт]				+
	Хэмжээ [Размер]	2/4				+
4/4			+			
6/8		+				
3/4				+		
ИХЭЛ ТАТАХ АРГА БАРИЛ	Ихэл татах арга	Татах, түлхэх	+	+	+	+
		Гүйлгэх	+		+	
		Сийгүүлэх				
		Ижгэрүүлэх				
		Товшиж татах		+		+
	Нумын техник	Шулуун	+		+	
		Огцом				+
		Сугсраа		+		
		Үсэргээ		+		
		Холбоо	+		+	+
		Том	+		+	+
		Жижиг		+		

ИХЭЛ ТАТАХ АРГА БАРИЛ	Цохилгын хэлбэр	Жигрүүлэх				
		Дүн	+	+	+	+
		Давхар	+		+	
		Далд		+		
		Утгаа				+
		Солбицоо				
		Залгаа	+	+	+	+
	Дарлагын төрөл	Битүү				
		Гулсаа [Глиссандо]				
		Чигиргээ		+		
Шувтгаа		+		+	+	

Баяд бийгийн татлагын талаар ихэлч Ж.Хумбаатай хийсэн ярилцлагаас онцлоход, “Тухайн угсаатны бүлэг бийгийн хэдэн төрөлтэй байна, ихэлээр татдаг бийгийн түдэн татлагатай байна гэсэн үг. Эдгээр татлагыг түдэн удаа татаад дуусгана гэсэн зүйл байхгүй. Бийч хэзээ дуусна тэр цагт дуусгана. Бийч бийг эхлүүлэхэд ихэлч зээг татаж эхэлнэ. Нэг эхэлсэн байхад ихэлийн татлага аялгуу бийг хөтөлж явна. Энэ нь цэвэр мэдрэмжийн асуудал. Хамгийн гол нь тухайн татлагыг зөв татах нь чухал. Баядууд хурим найрыг “Элхэндэг” бийгээр эхэлж, “Жороо морь” бийгээр чилээдэг уламжлалтай. Хурим найрын эхэнд “Элхэндэг” бийгийн татлага татдаг уламжлалыг тэрээр айлд орсон хүн эхлээд цай амсдагтай адил. Иймд найрын эхэнд ёслол хүндэтгэлтэйгээр энэхүү татлагыг татдаг” (Хумбаа 2016) хэмээсэн.

Эдгээр татлагуудыг Н.Магсаржав өөрийн докторын диссертацийн хүрээнд ихэлч Ж.Хумбаатай уулзан судалгаа авч, баяд татлагуудыг татуулж баримтжуулан ноотлосон бөгөөд өмнө нь ихэлч Ж.Хумбаа татсанаар баядын “Элхэндэг”, “Жороо морь”, “Ихэлээрээ наадья”, “Дөрвөн Ойрад” татлагууд ямар нэгэн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдэд хэвлэгдээгүй анх удаа ноотлогдож судалгааны эргэлтэд орж байгаагаараа шинэлэг болж байна.

“Элхэндэг”



Зураг 1. “Элхэндэг” бийгийн татлага

“Жороо морь”



Зураг 2. “Жороо морь” бийгийн татлага

Жороо морь: “Морины явдал, гишгэдийг таньж, ялгаж ярьдаг нь монголчуудын нүүдэлчний зан заншлаас бий болсон соёл” юм. Монголчууд жороо морины явдлыг хонин жороо, сайвар жороо, усан тэлмэн жороо гэх мэт нэрлэж байсан. Баядын “Жороо морь” бий нь бийчийн ур чадварыг илтгэсэн золбоолог бий юм (Эрдэнэцэцэг 2023, 22).

Баяд дуут бийгийн татлагын талаар Хумбаа “Зарим тохиолдолд ихэлч бийчинтэй дуулж, хамсран татах байдлаар оролцохыг хэлнэ. Анх ийм төрлийн татлага байгаагүй бийч өөрөө дуулж, хуургүй биелдэг байсан. Орчин цагт ийм төрөл байхаас өөр аргагүй болжээ учир нь дуут бийгийн маш олон татлагууд бий болсон байна. Угсаатны бүлэг бүрээр энэ нь өөр өөрөөр илэрнэ. Баядад “Ихэлээрээ наадъя” гэж хүн бүрийн мэддэг дуут бийгийн татлага бий” (Хумбаа 2016) гэжээ.

“Ихэлээрээ наадъя” дууны шүлэгт

Моднаанан дотраас л уталж л авлаав л (Модны дотроос л огтолж авлаа)
Моринаанан сүүлээс л сугалж л авлаав л (Мориныхоо сүүлээс л сугалж л авлаа)
Ийгээд хоёруулан ихлээрээ наадъя (Ингээд хоёулаа ихлээрээ наадъя)
Гоодаан² бариултай сайхан ихлээрэн
Госнаанан³ гануу дээр тавиад л татнаав л
Ийгээд хоёруулан ихлээрээ наадъя
Хуяраар жирийсэн гилаан хялгасаан⁴
Хуруунаанан⁵ үзүүрээр дараад л татнаав л
Ийгээд хоёруулан ихлээрээн наадъя гэж гардаг.

Ихлээрээ наадъя



Зураг 3. “Ихэлээрээ наадъя”
Дуут бийгийн татлага

Дөрвөн Ойрад



Зураг 4. (Б). “Дөрвөн Ойрад”
Ихэлийн татлага

Баяд ихэлийн татлагын талаар ихэлч Ж.Хумбаа:

Ихэлийн татлага гэдэг нь ихэлээр татдаг бийгүй татлагуудыг хэлнэ. Ихэлийн татлагууд ихэвчлэн домгоос бий болсон байдаг. Баядад ихэлийн олон татлага байх бөгөөд эдгээр татлагууд нь ямар цагт, хэрхэн үүссэн, ямар утга бэлгэдэлтэй болохоос хамаарч утга санаа нь өөр өөр байна. Баядууд ихэлийн уламжлалт татлагаа татахдаа язгуур барилаар татдаг байсан. Язгуур барил гэдэг нь “Ихэлээрээ наадъя” дуунд гардагчлан госнаанан гануу дээр ихэлээ тавьж, мөрөн дээрээ ишийг нь налуулж дээрээс нь дарж татахыг хэлнэ. Энэхүү уламжлал одоо маргагдаж үгүй болсон нь харамсалтай. Жишээ нь: Ихэлийн уламжлалт татлага болох “Дөрвөн Ойрад”-ыг эмэгтэй хүн татдаггүй тэр тусмаа олон хүүхэдтэй эх хүн татдаггүй, хуурчдаа

² Гоодаан – Эгц, шулуун

³ Гос – Гутал


⁴ Хялгасаан - Хялгас

⁵ Хуруунаанан үзүүр - Хурууны үзүүр буюу ихэл татах аргын тухайд хурууны дарлага

хүнддэнэ гэж үзэж байжээ. (Өөрөө уг татлагыг нэг их татдаггүй хааяа татдаг гэв.) Тус татлагын удаан хэсэг алаг дааганаас болж дүрвэн нүүж буй их нүүдэл, гэрийн буйр дээр үлдсэн амьтдын гаслахуй чимээг илэрхийлдэг бол хурдан хэсгийн аялгуу нь эр хүний хийморь, дайнд ялалт байгуулаад ирж буй баатар эрсийн цог жавхланг илтгэх тул аливаа найр, наадам, ёслол хүндэтгэлийн арга хэмжээг энэхүү татлагаар эхлүүлдэг нь эргэн уулзах, эв нэгдэл, эрч хүчийг бэлгэдэн ийнхүү татаж байсан (Хумбаа 2016) тухай онцолсон юм.

Хэлэлцүүлэг

Ихэлч Ж.Хумбаагийн татсанаар “Элхэндэг”, “Жороо морь”, “Ихлээрээ наадъя”, “Дөрвөн Ойрад” татлагуудад ажиглалт хийж дээр дурдсан ангилал зүйн дагуу авч үзэн, *Зураг 5-д* үзүүлэв.



Зураг 5. Ихэлч Ж.Хумбаагийн ихэл татах арга барилын онцлог “Элхэндэг”, “Жороо морь”, “Ихлээрээ наадъя”, “Дөрвөн Ойрад” татлагын жишээн дээр

Дүгнэлт

Баядын ихэлч Жутаан Хумбаагийн ихэл татах арга барилын онцлогийг тодруулах зорилгоор хийсэн энэхүү ажлын үр дүнд ихэлийн татлагыг 3 төрлөөр, ихэлийн татлагад илрэх шинжийг 3 төрөл 13 зүйлээр, ихэл татах аргыг 4 төрөл 23 зүйлээр ангилан үзэж үр дүнг гаргав. Үүнд:

Ихэлийн татлагад илрэх шинжээр Баяд татлагын онцлогийг тодруулав. Үүнд:

- Хурдын хувьд - Тэнүүн, аядуу, тайван байдлаар илэрч байна.

- Хөгийн хувьд - Бийгийн татлагууд нь дөрөвц хөгөөр, ихэлийн уламжлалт татлагаа тавц хөгөөр татаж байна.
- Хэмжээний хувьд - Бийгийн татлагаа ихэвчлэн 6/8 хэмжээнд татаж байна. Тухайн татлага аялгуунаасаа хамаарч хэмжээ нь өөр өөр байх бөгөөд ихэнх тохиолдолд 6/8, 3/4, 4/4 хэмжээнд татагдаж буйг тодруулав.

Ихэлч Ж.Хумбаа доорх төрөл зүйлээс өөрийн гэсэн ихэл татах ямар аргыг эзэмшсэн өвлөн уламжлагч болохыг олж тодруулав. Үүнд:

- Ихэл татах аргын тухайд: Нумыг жигд татаж, түлхэх, гүйлгэх, сийгүүлэх, исгэрүүлэх, товшиж татах гэх мэт 5 төрөл зүйлээс нумыг жигд татаж, түлхэх, гүйлгэх аргыг эзэмшжээ.
- Нумын техникийн тухайд: Шулуун, огцом, сугсраа, үсэргээ, холбоо гэх таван төрөл зүйлээс шулуун, огцом, сугсраа, холбоо таталтуудыг эзэмшсэн байна.
- Цохилгын тухайд: Том, жижиг, жиргүүлэх, дан, давхар, далд, угтаа, солбио, залгаа гэх мэт 9 төрөл зүйлээс том, жижиг, дан, давхар цохилгуудыг эзэмшжээ.
- Дарлагын тухайд: Битүү, гулсаа, чичиргээ, шувтраа гэх мэт 4 төрөл зүйлээс гулсаа, шувтраа дарлагыг эзэмшсэн өвлөн уламжлагч болохыг тодруулав.

Ашигласан материалын жагсаалт

Зулцэцэг, Эрдэнэбэлэг. 2019. “Минимал шинж хөгжмийн зохиомжийн арга барил болох нь.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Соёл урлагийн их сургууль. 2018. *Соёл урлагийн тайлбар толь, Боть V: Бүжиг*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Энхцэцэг, Данзан. 2011. “Хуурын татлага Монголын хөгжмийн соёлын феномен болох нь.” Ph.D дисс., Монгол Улсын их сургууль.

Эрдэнэцэцэг, Шинэн. 2023. *Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг тогтворжуулах нь*. Улаанбаатар: Нандир ХХК.

Эрдэнэчимэг, Лувсанноров. 1994. *Хуурын татлага*. Улаанбаатар: Шувуун саарал ХХК.

Ярилцлага:

Жутаан Хумбаатай хийсэн ярилцлага. Увс аймгийн Улаангом сум: “Ойрад түмэн-2016” олон улсын язгуур урлагийн наадам, 2016.